

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ АСУУДЛААР ЯВУУЛСАН АНХДУГААР ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН ТАЙЛАНГ ҮНДЭСЛЭН ЗӨВЛӨЛДӨХ ЗӨВЛӨЛӨӨС УЛСЫН ИХ ХУРАЛД ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу Үндэсний статистикийн хорооноос 2017.5.1-ний өдөр ирүүлсэн “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар явуулсан анхдугаар зөвлөлдөх санал асуулгын дүнгийн тайлан”-г Зөвлөлдөх зөвлөл 2017.5.3-ны өдрийн хурлаараа эцэслэн хэлэлцээд дараах зөвлөмжийг гаргав.

1. Улсын Их Хурал, Засгийн газрын эрх мэдлийн хяналт-тэнцлийг хангах

1.1 Засгийн газрын бүрэлдэхүүнээ тогтоох, гишүүдийг томилох, чөлөөлөх эрхийг Ерөнхий сайдад олгох

Энэ асуудлаар эхний судалгаагаар дундаж утга 0.641 байснаа 0.782 болж 0.141-ээр өөрчлөгджээ. Эхний судалгаанд 6-10 оноог нөхсөн 57.1 хувь байгаа бол хоёр дахь санал асуулгаар 72.7 хувь болж өссөн байна. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд авч үзэх боломжтой.

1.2 Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс дээшгүй хувь нь Улсын Их Хурлын гишүүн байж болохоор хязгаарлах

Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээсдээшгүй хувь нь Улсын Их Хурлын гишүүнээр давхар ажиллаж болохоор хязгаарлах шаардлагагүй гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын гишүүнээр давхар ажиллахыг дэмжээгүй байна. Эхний судалгаагаар дундаж утга 0.431 байснаа хоёр дахь судалгаагаар дундаж утга 0.405 болж 0.025-аар буурчээ. Эхний судалгаагаар хамрагдсан хүний 52.5 хувь нь, хоёр дахь судалгаагаар 53.4 хувь нь 0-4 оноог сонгосон байна. Энэ нь дундаж утгад ойрхон байгаа учраас зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд оновчтой болгож тусгах эсэхийг авч үзвэл зохилтой.

1.3 Засгийн газрын бүтцийг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоож, бүтцийн хувьд төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах зорилгоор яамдын нэрийг хуульд заан тусгах.

Энэ асуудлаар эхний судалгаагаар дундаж утга 0.779 байснаа хоёр дахь судалгаагаар дундаж утга 0.814 болж 0.035-аар өөрчлөгдсөн. Хоёр дахь судалгаар хамрагдсан хүний 78.9 хувь нь, эхний судалгаагаар 73.0 хувь нь 6-10 оноог сонгосон байна. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжтой.

2. Үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, энэ чиглэлд ажил, үүргийн давхардлыг арилгах үүднээс Ерөнхийлөгчийн эрх, үүргийг тодорхой болгох

2.1 Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 6 жил байх, улируулан сонгохгүйгээр Улсын Их Хурлын өргөтгөсөн хуралдаанаас сонгодог болох (Улсын Их Хурлын өргөтгөсөн хуралдааны бүрэлдэхүүн нь Улсын Их Хурлын 76 гишүүн, аймаг, нийслэл, хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт гишүүдээс бүрдэнэ)

2.1.1 Ерөнхийлөгчийг нэг л удаа 6 жилээр сонгодог болох

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.640, хоёр дахь судалгаагаар 0.471 болж 0.169-өөр өөрчлөгджээ. Эхний судалгаанд хамрагдсан хүний 60.6 хувь нь, хоёр дахь судалгаагаар 40.9 хувь 6-10 оноог сонгожээ. Өөрөөр хэлбэл, мэдээлэл аваагүй эхний шатны судалгаанд оролцогсдын олонхи нь дэмжсэн бол хоёр дахь судалгаанд мэдээлэл авч хэлэлцсэний дараа олонхи нь дэмжихгүй болж өөрчлөгдсөн байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулахад энэ байдлыг харгалзан үзүүштэй.

2.1.2 Ерөнхийлөгчийг нэг л удаа 6 жилээр сонгохдоо УИХ-ын гишүүд, аймаг, нийслэл, хотын иргэдийн төлөөлөгчдийн хурлын нийт гишүүдээс сонгодог болох

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.390, хоёр дахь судалгаагаар 0.381 болжээ. Эхний судалгаагаар 57.4 хувь нь, хоёр дахь судалгаагаар 56.7 хувь нь 0-4 оноог сонгожээ. Өөрөөр хэлбэл, олонхи нь Ерөнхийлөгчийг нэг л удаа 6 жилээр сонгохдоо УИХ-ын гишүүд, аймаг, нийслэл, хотын иргэдийн төлөөлөгчдийн хурлын нийт гишүүдээс сонгодог болохыг дэмжээгүй байна. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулахдаа харгалзаж үзэх шаардлагатай.

2.2 Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн зарим бүрэн эрхийг өөрчилж, хууль санаачлах, Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг гаргах эрхийг хасах.

2.2.1. Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийг болиулах

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.466, хоёр дахь судалгаагаар 0.497 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 37.5 хувь нь, хоёр дахь судалгаагаар 39.5 хувь нь 6-10 оноог, эхний судалгаагаар 45.3 хувь нь, хоёр дахь судалгаагаар 39.5 хувь нь 0-4 оноог, эхний судалгаагаар 17.3 хувь нь, хоёр дахь судалгаагаар 22.6 хувь нь 5 гэсэн дундаж оноог тус тус сонгожээ. Энэ нь дундаж утгад ойрхон, хэлбэл нь харьцангуй бага байгаа учраас зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд оновчтой болгож тусгах асуудлыг авч үзэх боломжтой.

2.2.2 Ерөнхийлөгчийн Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг гаргах эрхийг болцуулах

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.455, хоёр дахь судалгаагаар 0.498 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 36.5 хувь нь, хоёр дахь судалгаагаар 41.2 хувь 6-10 оноог, эхний судалгаагаар 45.8 хувь нь, хоёр дахь судалгаагаар 41.8 хувь нь 0-4 оноог, эхний судалгаагаар 17.7 хувь нь, хоёр дахь судалгаагаар 17.1 хувь нь 5 гэсэн дундаж оноог тус тус сонгожээ. Энэ нь дундаж утгад ойрхон, хэлбэл нь харьцангуй бага байгаа учраас зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд оновчтой болгож тусгах шаардлагатай эсэхийг авч үзэх боломжтой.

2.2.3 Ерөнхийлөгч Засгийн газарт чиглэл өгөх нь Ерөнхий сайдыг засаглалын хувьд хангалттай эрх мэдэлтэй байлгахгүй байна

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.635, хоёр дахь судалгаагаар 0.635 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 54.7 хувь нь, хоёр дахь судалгаагаар 50.4 хувь 6-10 оноог, эхний судалгаагаар 23.8 хувь нь, хоёр дахь судалгаагаар 21.0 хувь нь 0-4 оноог, эхний судалгаагаар 21.6 хувь нь, хоёр дахь судалгаагаар 28.6 хувь нь 5 гэсэн дундаж оноог тус тус сонгожээ. Энэ нь 2.2-ын гол үндэслэл болж буй тул Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулахдаа харгалзаж үзэх нь зохистой.

3. Улс төрөөс хараат бус, мэргэшсэн, чадварлаг, нэр хүндтэй төрийн албыг бэхжүүлэх

3.1 Төрийн албаны Зөвлөлийг улс төрөөс хараат бус, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх мэдлийн байгууллага болгох

3.1.1 Төрийн албаны Зөвлөлийн бие даасан хараат бус байдлыг Үндсэн хуулиар хамгаалах заалт нэмэх

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.835, хоёр дахь судалгаагаар 0.823 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 80.2 хувь нь, хоёр дахь судалгаагаар 78.2 хувь 6-10 оноог сонгожээ. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжтой.

3.1.2 Улс төрийн намын харьяалалгүй байх

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.782, хоёр дахь судалгаагаар 0.821 болж өөрчлөгджээ. Эхний судалгаанд хамрагдсан хүний 73.1 хувь нь, хоёр дахь судалгаагаар 78.7 хувь 6-10 оноог, сонгожээ. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжтой.

3.2 Төрийн жинхэнэ албыг мэргэшсэн, тогтвортой, шатлан дэвших зарчимд шилжүүлэх

3.2.1 Төрийн жинхэнэ албыг мэргэшсэн, мэдлэг чадварт суурилсан, улс төрөөс ангид байх заалт нэмэх

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.905, хоёр дахь судалгаагаар 0.900 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 88.2 хувь нь, хоёр дахь судалгаагаар 87.6 хувь 6-10 оноог сонгожээ. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд шууд тусгах боломжтой.

3.2.2 Төрийн жинхэнэ албанд томилох, тушаалд шатлан дэвшүүлэх, ажлын байрны тогтвортой байдлыг хангахдаа мэдлэг чадварт суурилсан зарчим баримтлах

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.911, хоёр дахь судалгаагаар 0.914 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 90.3 хувь нь, хоёр дахь судалгаагаар 91.3 хувь 6-10 оноог, сонгожээ. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжтой.

3.3.3 Төрийн албан хаагчийг сонгуулийн үр дүн эсвэл улс төрийн үзэл бодлоос нь хамаарч ажлаас халахгүй байх заалт нэмэх

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.915, хоёр дахь судалгаагаар 0.909 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 90.4 хувь нь, хоёр дахь судалгаагаар 90.3 хувь нь 6-10 оноог, сонгожээ. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд шууд тусгах боломжтой.

4. Засаг захиргаа, нутгийн удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлэх

4.1 Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэл, хотод, аймаг нь сум, хотод (орон нутгийн харьяалалтай), сум нь баг болон тосгонд, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд, хот нь хороонд хуваагдахаар тус тус Монгол Улсын Үндсэн хуульд бэхжүүлэх

4.1.1 Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхой болгож Үндсэн хуульд аймаг нь сум, хотод (орон нутгийн харьяалалтай), сум нь баг болон тосгонд, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд, хот нь хороонд хуваагдахаар тус тус оруулах

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.794, хоёр дахь судалгаагаар 0.686 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 76.1 хувь нь, хоёр дахь судалгаагаар 59.8 хувь 6-10 оноог, эхний судалгаагаар 10.5 хувь нь, хоёр дахь судалгаагаар 19.2 хувь нь 0-4 оноог, эхний судалгаагаар 13.4 хувь нь, хоёр дахь судалгаагаар 21.1 хувь нь 5 гэсэн дундаж оноог тус тус сонгожээ. Энд эхний дэмжиж байсан боловч мэдээлэл авч харилцан зөвлөлдсөний дараа дэмжсэн байр суурь багасах хандлага ажиглагдаж буй учраас зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжтой.

4.1.2 Баг, хороо, тосгоны Засаг даргыг улсын чанартай хот болон сум, дүүргийн Засаг дарга шууд томилдог болох

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.479, хоёр дахь судалгаагаар 0.628 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 44.2 хувь нь, хоёр дахь судалгаагаар 57.7 хувь нь 6-10 оноог, эхний судалгаагаар 48.8 хувь нь, хоёр дахь судалгаагаар 30.7 хувь нь 0-4 оноог, эхний судалгаагаар 7.0 хувь нь, хоёр дахь судалгаагаар 11.8 хувь нь 5 гэсэн дундаж оноог тус тус сонгожээ. Энд эхний судалгаанд дэмжихгүй байр суурь

давамгаалж байсан бол мэдээлэл авч харилцан зөвлөлдсөний дараа дэмжсэн байр суурь давамгайлах болсон учир зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэнхуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжтой.

5.Төрийн хариуцлага, сахилга, шударга ёсыг бэхжүүлэх, хууль хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах

5.1 Улс төрөөс ангид төрийн хариуцлага, сахилгыг дээшлүүлэх Үндсэн хуулийн байгууллага бий болгох

5.1.1 Төрийн хариуцлага, сахилгыг дээшлүүлэх арга, механизмыг Үндсэн хуульд бий болгох

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.934, хоёр дахь судалгаагаар 0.900 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 94.2 хувь нь, хоёр дахь судалгаагаар 89.2 хувь нь 6-10 оноог сонгожээ. Энд Үндсэн хуульд байгууллага бий болгох тухай асуудлыг биш харин арга, механизмыг бий болгох тухай асуултаар мэдээлэл авагдсан учраас энэ байдлыг харгалзан зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжийг авч үзэх нь зохилтой.

5.2 Төрийн хариуцлагыг дээшлүүлэх, авлигатай тэмцэх бодлого, хэрэгжилтийг хангах, нийгмийн шударга ёсыг сахин хамгаалах байгууллагыг улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус, бие даасан байгууллага болгон зохион байгуулах;

5.2.1 Төрийн хариуцлагыг дээшлүүлэх, авлигатай тэмцэх бодлого, хэрэгжилтийг хангах парламентын бүтэц байгуулах

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.881, хоёр дахь судалгаагаар 0.802 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 87.5 хувь нь, хоёр дахь судалгаагаар 75.8 хувь 6-10 оноог сонгожээ. Энд мөн Үндсэн хуульд улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус, бие даасан байгууллага бий болгох тухай асуудлыг биш харин парламентын бүтцийн буюу хоёр дахь хэлэлцүүлгийн үед яригдсан түр хорооны тухай асуултаар мэдээлэл авагдсан учраас энэ байдлыг харгалзан зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжийг авч үзэх боломжтой.

5.3 Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах ёстой Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, шүүгч, Ерөнхий шүүгчийг томилох томилгооны зарчмыг тодорхой болгох

5.3.1 Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.713, хоёр дахь судалгаагаар 0.772 болж өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 66.5 хувь нь, хоёр дахь судалгаагаар 70.8 хувь

нь 6-10 оноог сонгожээ. Хоёр дахь хэлэлцүүлгийн үед Шүүхийн Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх асуудлыг бусад хуулиар зохицуулах бололцоо байгаа учраас Үндсэн хуульд оруулах шаардлагагүй гэсэн санал гарч байсныг харгалзан зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжийг авч үзэхээр байна.

5.3.2 Шүүгч, Ерөнхий шүүгчийг томилох томилгооны зарчмыг тодорхой болгох

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.881, хоёр дахь судалгаагаар 0.864 болж өөрчлөгджээ. Эхний судалгаанд хамрагдсан хүний 87.5 хувь нь, хоёр дахь судалгаагаар 82.6 хувь 6-10 оноог сонгожээ. Үүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах боломжтой.

6. Төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал, хууль тогтоох байгууллага-Улсын Бага хурал гэсэн хоёр танхимтай байх хэлэлцэх нөхцөлийг хангах.

6.1 Төрийн эрх барих дээд байгууллага нь Ардын Их Хурал, хууль тогтоох байгууллага-Улсын Бага хурал гэсэн хоёр танхимтай байх

Дундаж утгаар нь авч үзвэл эхний судалгаагаар 0.627, хоёр дахь судалгаагаар 0.356 болж эрс өөрчлөгджээ. Эхний судалгаагаар 58.3 хувь нь, хоёр дахь судалгаагаар 31.6 хувь нь 6-10 оноог, эхний судалгаагаар 30.1 хувь нь, хоёр дахь судалгаагаар 60.6 хувь нь 0-4 оноог, эхний судалгаагаар 11.6 хувь нь, хоёр дахь судалгаагаар 7.8 хувь нь 5 гэсэн дундаж оноог тус тус сонгожээ. Энд эхний судалгаагаар дэмжиж байсан боловч мэдээлэл авч харилцан зөвлөлдсөний дараа дэмжсэн байр суурь огцом багассан нь хоёр дахь шатны хэлэлцүүлгийн үед Үндсэн хуулийн суурь бүтэц, үзэл баримтлалыг өөрчлөхөд хүрнэ гэсэн асуудал хүчтэй хөндөгдсөнтэй холбоотой байж болох учраас зөвлөлдөх санал асуулгын 2 дахь шатны чанарын судалгаа болон бусад холбогдох судалгааны мэдээллээр тодруулсны үндсэн дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах эсэх асуудлыг авч үзвэл зохистой.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар санал асуулга явуулах Зөвлөлдөх зөвлөлийн бүрэлдэхүүн:

Ц.Гомбосүрэн

Н.Жанцанноров

Д.Ламжав

Б.Лхагважав

Ц.Сарантуяа

Д.Сүхжаргалмаа

Д.Чойжамц

Г.Чулуунбаатар

Төрийн ордон. 2017.05.03